




**ЗАВХАН АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/ Факс: 7046-3070
И-мэйл: zavkhan@sport.gov.mn

2025. 11.28 № 108
танай _____-ны № _____ т

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН
ХОРООНД**

2025 оны хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн
жилийн эцсийн тайлагналтыг хүргүүлж байна.
Хавсралт: 1. хуудастай

ДАРГА  М.БАТБАЯР



 دپارتمان ورزش و جوانان
 دپارتمان ورزش و جوانان

آدرس: تهران، خیابان ولیعصر، پلاک ۱۸، طبقه ۸
 تلفن: ۷۰۴۶-۳۰۷۰
 ایمیل: zavkhan@sport.gov.ir

شماره و نام خانوادگی: _____
 و نام: _____
 و نام: _____

دپارتمان ورزش و جوانان، تهران، ایران

تاریخ: _____

در تاریخ ۱۳۹۸/۰۵/۰۵، در جلسه کمیته فنی و تخصصی ورزش و جوانان، موضوع: _____
 در تاریخ ۱۳۹۸/۰۵/۰۵، در جلسه کمیته فنی و تخصصی ورزش و جوانان، موضوع: _____
 در تاریخ ۱۳۹۸/۰۵/۰۵، در جلسه کمیته فنی و تخصصی ورزش و جوانان، موضوع: _____

امضاء: _____
 دپارتمان ورزش و جوانان
 تهران، ایران

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
ЗАВХАН АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

2025 ОН

2025 оны 11 сарын 25

2025 оны 11 сарын 25									
Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ	Үнэлгээний тайлбар		
1	1	Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх тухай	1 Монгол Улсын хүн амын орчин үеийн эрүүл амьдралын хэв маяг, зан үйлд сургах, аливаа саад, бэрхшээлийг даван туулах бие, сэтгэлийн тэсвэр хатуужилтай шинэ үеийг бий болгох зорилгоор "Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил"-ыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар жил бүрийн дөрөвдүгээр сард явуулж, үнэлэлт, дүгнэлтийг үндэслэн шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай.	МУЕЗарлиг 2025 оны 04-05 дугаар сард "Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг аймгийн хэмжээнд нийт 3485 иргэнээс авсан бөгөөд үүнээс А үнэлгээтэй 1007, В үнэлгээтэй 1221, С үнэлгээтэй 571, D үнэлгээтэй 143, F үнэлгээтэй 543 иргэн үнэлэгдсэн байна. Завхан аймгийн Улиастай сумын төрийн байгууллагуудын албан хаагчдыг хуваарийн дагуу сорилд хамруулж албан хаагчдад зөвлөн туслан үйлчилгээ үзүүлж ажилласан. Мөн Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвтэй хамтран Завхан аймгийн өсвөрийн шигшээ багийн спортын 6 төрлийн 51 тамирчин хамрууллаа. Тус сорил нь өсвөрийн тамирчдын бие бялдрын ерөнхий хөгжил, биеийн бүтэц, баланс, сэтгэл зүйн байдал, хоол шим тэжээлийн байдлыг сорил тест болон асуумжийн аргаар судлах, суурь судалгааны мэдээлэл цуглуулах, өсвөрийн тамирчидтай ажиллаж байгаа дасгалжуулагч нарыг орчин үеийн спортын шинжлэх ухаан, анагаах ухааны мэдлэг, мэдээллээр хангасан.	85				
		2010.03.26							
		дугаар 53	2.Биеийн тамир, спортыг нийтийн үйл хэрэг болгох зорилгоор дунд болон их, дээд сургуулиудад биеийн тамир, спортыг сургалтын тэргүүлэх чиглэл болгож, сурагч, оюутнуудыг спортоор хичээллэх таатай орчин нөхцөлөөр хангах, спортын хамтлаг, клубын тогтолцоог нэвтрүүлж ажиллахыг төрийн болон төрийн бус байгууллага, тамирчид, багш дасгалжуулагчид, бизнесийн бүх байгууллага, нийт ард иргэдэд уриалсугай.	Завхан аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд Түдэвтэй суманд нийтийн спортын талбай байгуулах, Их-Уул сумын сургуулийн спорт заалны шалыг агч модон шалаар сольж засварлах, Тэлмэн сумын сургуульд биеийн тамирын талбай байгуулах, Тэс сумын ЕБС-ийн спорт заалны барилгын ажлыг дуусгах, Нөмрөг сумын спорт заалыг засварлах, Улиастай сумын ЕБ-ын ЧЭС-ийн спорт заалны шалыг агч одон шалаар сольж засварлах, Улиастай сумын Жавхлант цогцолбор сургуулийн спорт зааланд агч модон шал шинээр хийх, Улиастай сумын 4-р цэцэрлэгийн биеийн тамирын талбайг тохижуулах. Бүс, Улс, ОУ-ын тэмцээнд оролцож амжилт гаргасан тамирчид, дасгалжуулагчдыг шагнаж урамшуулах, аймгийн Засаг даргын дэргэдэх "Өсвөрийн шигшээ баг"-ийн үйл ажиллагааг дэмжиж, уралдаан тэмцээн зохион байгуулж Улс, Бүс, ОУ-ын тэмцээнд тамирчдыг оролцуулах, Их-Уул сумын ЕБС-д "Волейбол"-ын гадна талбай авах зэрэг ажлууд тусгагдаж нийт 1,227,300,000 төгрөгийг зарцуулж ажлын гүйцэтгэл 100 хувьтай байна.	100				
Хэсгийн дундаж					92.50%				
2	2	Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2021-10-19 Дугаар 2021 №8 БСШУСБХ	1.5/ бүх шатны боловсролын сургалтын байгууллагын биеийн тамирын хичээлийн хөтөлбөр агуулгыг боловсронгуй болгох, тоног төхөөрөмж, материаллаг баазыг бэхжүүлэх, суралцагчдыг спортын секц, дугуйланд хамран суралцуулах бололцоог бүрдүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Ерөнхий боловсролын 29 сургуулийн биеийн тамирын багшийн хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор нийт 71 багшаас 65 багшийн 65 цагийн хичээлд сууж, нэгж, ээлжит хичээлийн хөтөлбөртэй танилцан зөвлөн туслалх ажлыг зохион байгууллаа. Ерөнхий боловсролын 29 сургуулийн 1-12-р ангийн давхардсан тоогоор 60000 гаруй суралцагч 17 төрлийн дугуйлан секцэд хамрагдаж байна. Мөн Аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд Улиастай сумын ЧЭС-ийн спортын заалны шалыг солихоор 98,0 сая төгрөг, Жавхлант цогцолбор сургуулийн спорт заалны шалыг солихоор 95,0 сая төгрөг, Нөмрөг сумын сургуулийн заалны шалыг солихоор 150,0 сая төгрөг тус тус төсвөөс хэрэгжүүлж ажиллаж байна.	100				
			1.6/ Биеийн тамирын багш, дасгалжуулагч, арга зүйч, мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, тэдгээрийг гадаад улсад бэлтгэх, мэргэшүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Биеийн тамир, спортын байгууллагад чадварлаг мэргэжилтэн бэлтгэхээр Чөлөөт бөхийн олон улсын шүүгч Б.Гансүх "Улаанбаатар Ороп-2025" Дэлхийн ранжын чөлөөт бөхийн олон улсын тэмцээнийг шүүж, сонгомол бөхийн дүрэм, шүүгчийн зэргээ ахиулах сургалтад хамрууллаа. Мөн Биеийн тамир, спортын газрын самбо, жүдо бөхийн дасгалжуулагч Д.Баянмөнхийг туршлага судлах, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Узбекистан улсын Ташкент хотод 2025 оны 04 сарын 15-20-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Самбо бөхийн ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд өсвөр, залуучууд, сурагч, мастеруудын Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлж 7 тамирчин, 1 дасгалжуулагч оролцож 1 алт, 2 мөнгө, 3 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүлсэн.	100				
			1.12/ Нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдийн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх, спортын барилга байгууламж, заал, талбайн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, жил бүрийн улсын төсвийн төсөлд биеийн тамир спортын салбарын зардлыг нэмэгдүүлэх талаар анхаарч ажиллах.	Завхан аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд Түдэвтэй суманд нийтийн спортын талбай байгуулах, Их-Уул сумын сургуулийн спорт заалны шалыг агч модон шалаар сольж засварлах, Тэлмэн сумын сургуульд биеийн тамирын талбай байгуулах, Тэс сумын ЕБС-ийн спорт заалны барилгын ажлыг дуусгах, Нөмрөг сумын спорт заалыг засварлах, Улиастай сумын ЕБ-ын ЧЭС-ийн спорт заалны шалыг агч одон шалаар сольж засварлах, Улиастай сумын Жавхлант цогцолбор сургуулийн спорт зааланд агч модон шал шинээр хийх, Улиастай сумын 4-р цэцэрлэгийн биеийн тамирын талбайг тохижуулах. Бүс, Улс, ОУ-ын тэмцээнд оролцож амжилт гаргасан тамирчид, дасгалжуулагчдыг шагнаж урамшуулах, аймгийн Засаг даргын дэргэдэх "Өсвөрийн шигшээ баг"-ийн үйл ажиллагааг дэмжиж, уралдаан тэмцээн зохион байгуулж Улс, Бүс, ОУ-ын тэмцээнд тамирчдыг оролцуулах, Их-Уул сумын ЕБС-д "Волейбол"-ын гадна талбай авах зэрэг ажлууд тусгагдаж нийт 1,227,300,000 төгрөгийг зарцуулж ажлын гүйцэтгэл 100 хувьтай байна.	100				
		Биеийн тамир, спортын тухай хууль 2024.06.05 23 дугаар зүйлийн 23.5	Аймаг, дүүргийн Засаг дарга нь аймаг, дүүргийн өсвөр үеийн шигшээ багт орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх бөгөөд аймаг, дүүргийн биеийн тамир, спортын газар нь спортын 10-аас доошгүй төрлөөр спортын холбооны орон нутаг дахь салбартай хамтран сонгон шалгаруулж, үйл ажиллагааг нь зохион байгуулна.	Завхан аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд Бүс, Улс, ОУ-ын тэмцээнд оролцож амжилт гаргасан тамирчид, дасгалжуулагчдыг шагнаж урамшуулах 30,000,000 сая төгрөг, аймгийн Засаг даргын дэргэдэх "Өсвөрийн шигшээ баг"-ийн үйл ажиллагааг дэмжиж, уралдаан тэмцээн зохион байгуулж Улс, Бүс, ОУ-ын тэмцээнд тамирчдыг оролцуулах 100,000,000 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн бөгөөд Завхан аймгийн өсвөрийн шигшээ багийн баг болон бусад тамирчид бүс, улс, олон улс, тив дэлхийн тэмцээнээс нийт 226 медаль хүртсэн амжилт үзүүлсэн.	100				
		Биеийн тамир, спортын тухай хууль 2024.06.05 30 дугаар зүйлийн 30.2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх, спортын тэмцээн, наадамд оролцоход төрийн байгууллага,спортын холбоо, спортын клуб дэмжлэг үзүүлж ажиллана.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг спортын тэмцээн уралдаанд тогтмол оролцуулах зорилгоор 7 хоног бүрийн лхагва гарагт 12-14 цагийн хооронд бэлтгэл хийлгэж спортоор хичээллэх боломжоор хангаж үнэ төлбөргүй үйлчилж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хичээллэх боломжоор хангаж софт волейболын 2 бөмбөг авч волейбол тоглох орчин нөхцөлөөр ханган ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг спортын тэмцээн наадамд оролцоход дэмжлэг үзүүлэх зорилгоор Монголын бүх ард түмний 16 дугаар их наадамд оролцох 32 тамирчинд замын зардал, Архангай аймагт зохион байгуулагдсан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн	100				
Хэсгийн дундаж					100%				
3	3	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 07 дугаар тогтоол 2022.01.05	Төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх	Байгууллагын албан ёсны сайт, цахим хуудсаар байгууллагын үйл ажиллагаа, спортын тэмцээн, уралдааны мэдээ, мэдээллийг тогтмол иргэдэд хүргэж Кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэхээр ажиллаж байна.	70				
			Төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам,заавар, стандартын дагуу хоёр бичгээр хөтлөх ажлыг туршиж	Байгууллагын албан бичиг, захирамжлалын баримт бичгийг журам, заавар, стандартын дагуу монгол бичгээр хөтлөн явуулж байна.	100				
			Төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх	Байгууллагын ажилтан, албан хаагчдад долоо хоногийн баасан гаригт монгол хэл, үндэсний бичгийн сургалт явагдаж байна.	100				
			Төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж хэвшүүлэх	Байгууллагын хаягийг кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн үйлдсэн.	100				
			Хэсгийн дундаж					95.00%	
Нийт									

ТАНИЛЦСАН: БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА М.БАТБАЯР
ХЯНАСАН: СПОРТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Г.ГАНБАТ
ТАЙЛАН НЭГТГЭСЭН: НИЙТИЙН БИЕИЙН ТАМИРЫН АРГА ЗҮЙЧ

6119279918
9039365 & 65119394